

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2024/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2024 он	Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас:70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас:70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: О.Мягмарсүрэн Утас: 70378845 Цахим хаяг: myagmarsureno@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3088, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 41
тантай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дархан сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Жижиг мөнгөн санд харилцагч байгууллагаас орсон 720.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансаар дамжуулаагүй зарцуулсан, шагналын дагалдах мөнгийг 800.0 мянган төгрөгөөр илүү тооцсон, захиалагчийн хяналтын зардал 400.0 мянган төгрөгийг ажил гүйцэтгэгчид олгосон, урсгал засварын ажлын зураг төсөвт тусгагдсан 12,976.2 мянган төгрөгийн ажлыг дутуу хийлгэсэн, нягтлан бодох бүртгэлд 15,324.0 мянган төгрөгийг тусгаагүй, цалин, хөлснөөс 2,544.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй зэрэг зөрчлүүд илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1, 13.5, 13.6, 13.7 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.14 дэх заалт, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6, 3.1-д заасныг тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "эрх ба үүрэг", "тасалбар болголт", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Дархан сумын ЗДТГ-ын даргын Б/40 дүгээр тушаалаар О.Сувданчимэг, Б/66 дугаар тушаалаар Б.Бат-Отгон, Б/88 дугаар тушаалаар Г.Рэнцэндулам нарыг тус тус нягтлан бодогчоор томилсноор зарлагын гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурж, нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож, 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн байна.

0090?0123

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан сумын ЗДТГ-ын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 160 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.9 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	353,131,219.97	369,859,650.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,000.00
31210	Төгрөг	-	1,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	-	1,000.00
33	АВЛАГА	24,162,133.00	16,724,879.53
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	192,747.53
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,630,001.00	-
33500	Бусад авлага	16,532,132.00	16,532,132.00
33510	Байгууллагаас авах авлага	16,532,132.00	16,532,132.00
35	БАРАА МАТЕРИАЛ	324,719,086.97	338,773,770.97
35100	Түүхий эд материал	1,788,500.00	288,500.00
35130	Эм боох материал	1,788,500.00	288,500.00
35400	Хангамжийн материал	322,930,586.97	338,485,270.97
35410	Бичиг хэргийн материал	8,819,400.00	10,900,300.00
35420	Аж ахуйн материал	250,826,726.97	269,160,590.97
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,279,600.00
35450	Барилгын засварын материал	242,000.00	19,684,320.00
35470	Бусад хангамжийн материал	63,042,460.00	36,460,460.00
36	НӨӨЦИЙН БАРАА	4,250,000.00	14,360,000.00
36300	Тэжээлийн нөөц	3,250,000.00	7,900,000.00
36500	Буудайн нөөц	1,000,000.00	6,460,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,145,781,235.60	12,239,767,151.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,145,781,235.60	12,239,767,151.79
39200	Биет хөрөнгө	8,978,215,375.44	9,073,176,151.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,058,286,757.20	8,058,286,757.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	(467,610,822.26)	(645,356,368.97)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	46,072,900.00	46,072,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,639,566.52)	(23,106,233.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	433,108,059.00	509,496,392.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(193,702,100.98)	(207,728,663.71)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	218,247,375.56	287,985,799.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	(112,169,326.38)	(137,104,463.38)
39209	Зам, гүүрийн байгууламж	1,722,960.00	294,846,584.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(704,497.26)	(2,623,727.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,592,778,901.59	1,581,478,501.59
39215	Хуримтлагдсан элэгдэл	(580,175,264.51)	(689,071,326.20)
39300	Биет бус хөрөнгө	3,167,565,860.16	3,166,591,000.20
39301	Програм хангамж	4,774,300.00	4,774,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,674,439.84)	(3,649,299.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,165,466,000.00	3,165,466,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,498,912,455.57	12,609,626,802.29
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,000.00

41300	Өглөг	-	1,000.00
41360	Бусад өглөг	-	1,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,498,912,455.57	12,609,625,802.29
51	Засгийн газрын хувь оролцоо	12,498,912,455.57	12,609,625,802.29
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,296,641,487.07	4,296,641,487.07
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,296,641,487.07	4,296,641,487.07
51200	Хуримтлагдсан үр дүн	7,041,216,988.08	7,151,930,334.80
51210	Өмнөх үеийн үр дүн	2,928,477,093.32	7,041,216,988.08
51220	Тайлант үеийн үр дүн	4,112,739,894.76	110,713,346.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,161,053,980.42	1,161,053,980.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,498,912,455.57	12,609,626,802.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,324,749,595.78	3,929,464,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,362,056,968.00	558,680,560.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,362,056,968.00	558,680,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,778,432.00	25,055,732.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,055,732.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,778,432.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	4,320,045,736.00	499,472,928.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,232,800.00	34,151,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,962,692,627.78	3,370,784,190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	115,751,450.00	51,427,211.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	7,630,001.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,751,450.00	43,077,210.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	720,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,846,941,177.78	3,319,356,979.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,846,941,177.78	3,319,356,979.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,200,601,367.84	3,724,802,565.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,200,601,367.84	3,724,802,565.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,966,381,340.42	3,640,356,007.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,713,670.41	1,701,034,700.00
210101	Үндсэн цалин	554,947,043.92	1,051,076,038.73
210102	Нэмэгдэл	110,776,700.68	327,736,693.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,524,733.00	198,083,259.39
210104	Урамшуулал	55,340,003.00	100,847,946.12
210105	Гэрээт ажлын хөлс	174,125,189.81	23,290,762.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,116,389.55	226,764,173.99
210201	Тэтгэврийн даатгал	87,241,242.58	158,862,965.37
210202	Тэтгэмжийн даатгал	10,246,813.95	16,960,239.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,890,567.45	13,618,471.43
210204	Ажилгүйдлийн даатгал	1,904,863.33	3,419,328.85
210205	Эрүүл мэндийн даатгал	19,832,902.24	33,903,169.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,527,376.87	158,101,865.50
210301	Гэрэл, цахилгаан	35,399,934.42	58,635,903.53
210302	Түлш, халаалт	55,387,234.69	75,016,787.73
210303	Цэвэр, бохир ус	6,740,207.76	19,049,174.24
210304	Байрны түрээс	6,000,000.00	5,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,173,607.72	229,691,834.18
210401	Бичиг хэрэг	21,777,850.00	38,511,000.00
210402	Тээвэр, шатахуун	28,598,250.00	32,412,620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,329,240.72	27,633,875.18
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,298,500.00	1,790,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,169,767.00	129,344,339.00

2105	Нормативт зардал	6,878,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,228,000.00	-
210502	Хоол, хүнс	650,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,033,400.00	299,537,586.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	104,500.00	2,856,000.00
210604	Урсгал засвар	29,928,900.00	296,681,586.00
2107	Томилолт, зочны зардал	4,590,600.00	4,046,739.18
210702	Дотоод албан томилолт	4,590,600.00	4,046,739.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,188,933.00	114,890,581.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,831,000.00	110,865,341.49
210803	Даатгалын үйлчилгээ	425,100.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,100.00	303,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,633.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	442,100.00	607,500.00
210807	Газрын төлбөр	2,178,000.00	2,842,546.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	509,159,362.87	906,288,527.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	207,539,643.81	523,405,353.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,595,000.00	6,550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	292,024,719.06	376,333,174.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	234,220,027.42	84,446,558.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	203,873,270.00	37,919,328.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	82,530,000.00	17,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,105,968.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,930,857.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,306,445.00	20,919,328.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,346,757.42	46,527,230.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,346,757.42	46,527,230.13
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,124,148,227.94	204,662,184.34
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,408,333.18	93,948,837.62
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	11,408,333.18	93,948,837.62
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,112,739,894.76	110,713,346.72

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,010,067,059.78	3,395,839,922.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,778,432.00	25,055,732.00
120	Нийтлэг татварын бус орлого	33,778,432.00	25,055,732.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,778,432.00	25,055,732.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	25,055,732.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,778,432.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,976,288,627.78	3,370,784,190.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	129,347,450.00	51,427,211.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,900,000.00	7,630,001.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,447,450.00	43,077,210.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	720,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,846,941,177.78	3,319,356,979.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,846,941,177.78	3,319,356,979.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,954,662,469.78	3,331,043,922.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,954,662,469.78	3,331,043,922.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,705,891,441.36	3,246,598,363.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	972,713,670.41	1,701,034,700.00
210101	Үндсэн цалин	567,627,043.92	1,054,021,588.44
210102	Нэмэгдэл	110,624,700.68	328,341,369.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	77,524,733.00	198,072,323.39
210104	Урамшуулал	55,340,003.00	100,858,882.12
210105	Гэрээт ажлын хөлс	161,597,189.81	19,740,536.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,116,389.55	226,956,921.52
210201	Тэтгэврийн даатгал	87,241,242.58	159,055,712.90
210202	Тэтгэмжийн даатгал	10,216,701.26	16,960,239.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,920,680.14	13,618,461.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,904,863.33	3,419,328.86
210205	Эрүүл мэндийн даатгал	19,832,902.24	33,903,179.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,527,376.87	157,810,365.50
210301	Гэрэл, цахилгаан	35,399,934.42	58,467,989.22
210302	Түлш, халаалт	55,387,234.69	74,893,202.04
210303	Цэвэр, бохир ус	6,740,207.76	19,049,174.24
210304	Байрны түрээс	6,000,000.00	5,400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	88,532,757.72	82,150,368.18
210401	Бичиг хэрэг	17,125,950.00	20,274,120.00
210402	Тээвэр, шатахуун	21,660,750.00	17,920,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,329,240.72	25,804,055.18
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,298,500.00	2,880,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,118,317.00	15,272,193.00

2105	Нормативт зардал	5,378,000.00	2,516,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,378,000.00	2,516,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,042,320.00	337,214,666.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,018,000.00	22,824,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,004,500.00	1,699,800.00
210604	Урсгал засвар	33,019,820.00	312,689,966.00
2107	Томилолт, зочны зардал	4,590,600.00	4,046,739.18
210702	Дотоод албан томилолт	4,590,600.00	4,046,739.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	113,515,933.00	228,075,445.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	110,158,000.00	224,050,205.49
210803	Даатгалын үйлчилгээ	425,100.00	250,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,100.00	303,194.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,633.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	442,100.00	607,500.00
210807	Газрын төлбөр	2,178,000.00	2,842,546.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,474,393.81	506,792,358.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,391,393.81	500,242,358.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,083,000.00	6,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	248,771,028.42	84,445,558.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	210,794,270.00	37,918,328.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	82,530,000.00	17,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,105,968.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,930,857.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	63,227,445.00	20,918,328.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37,976,758.42	46,527,230.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,346,757.42	41,683,219.13
213404	Хөрөнгийн	-	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,630,001.00	4,844,011.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	55,404,590.00	64,796,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	55,404,590.00	64,795,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	55,404,590.00	64,795,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	55,404,590.00	64,795,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	55,404,590.00	64,795,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(55,404,590.00)	(64,795,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	1,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,296,641,487.07	1,161,053,980.42	2,928,477,093.32	8,386,172,560.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,296,641,487.07	1,161,053,980.42	2,928,477,093.32	8,386,172,560.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
C05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C06	Тайлант үеийн үр дүн	-	-	4,112,739,894.76	4,112,739,894.76
C07	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,296,641,487.07	1,161,053,980.42	7,041,216,988.08	12,498,912,455.57
C08	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,296,641,487.07	1,161,053,980.42	7,041,216,988.08	12,498,912,455.57
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,296,641,487.07	1,161,053,980.42	7,041,216,988.08	12,498,912,455.57
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	110,713,346.72	110,713,346.72
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,296,641,487.07	1,161,053,980.42	7,151,930,334.80	12,609,625,802.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,521,651,900.00	3,302,728,491.87	(218,923,408.13)	93.78%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,521,651,900.00	3,302,728,491.87	(218,923,408.13)	93.78%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,482,095,900.00	3,264,810,163.87	(217,285,736.13)	93.76%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,701,034,700.00	1,701,034,700.00	-	100.00%
210101	Үндсэн цалин	1,113,319,600.00	1,054,021,588.44	(59,298,011.56)	94.67%
210102	Нэмэгдэл	303,451,300.00	328,341,369.54	24,890,069.54	108.20%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	154,957,100.00	198,072,323.39	43,115,223.39	127.82%
210104	Урамшуулал	102,182,500.00	100,858,882.12	(1,323,617.88)	98.70%
210105	Гэрээт ажлын хөлс	27,124,200.00	19,740,536.51	(7,383,663.49)	72.78%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	235,030,900.00	226,956,921.52	(8,073,978.48)	96.56%
210201	Тэтгэврийн даатгал	166,763,300.00	159,055,712.90	(7,707,587.10)	95.38%
210202	Тэтгэмжийн даатгал	17,066,900.00	16,960,239.28	(106,660.72)	99.38%
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,653,500.00	13,618,461.42	(35,038.58)	99.74%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,413,400.00	3,419,328.86	5,928.86	100.17%
210205	Эрүүл мэндийн даатгал	34,133,800.00	33,903,179.06	(230,620.94)	99.32%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	240,424,300.00	157,810,365.50	(82,613,934.50)	65.64%
210301	Гэрэл, цахилгаан	88,892,000.00	58,467,989.22	(30,424,010.78)	65.77%
210302	Түлш, халаалт	122,120,200.00	74,893,202.04	(47,226,997.96)	61.33%
210303	Цэвэр, бохир ус	18,884,000.00	19,049,174.24	165,174.24	100.87%
210304	Байрны түрээс	10,528,100.00	5,400,000.00	(5,128,100.00)	51.29%
2104	Хангамж, бараа материалын зардал	85,459,600.00	82,150,368.18	(3,309,231.82)	96.13%
210401	Бичиг хэрэг	20,037,000.00	20,274,120.00	237,120.00	101.18%
210402	Тээвэр, шатахуун	19,724,300.00	17,920,000.00	(1,804,300.00)	90.85%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,193,100.00	25,804,055.18	(1,389,044.82)	94.89%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,880,000.00	2,880,000.00	-	100.00%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,625,200.00	15,272,193.00	(353,007.00)	97.74%
2105	Нормативт зардал	3,833,800.00	2,516,800.00	(1,317,000.00)	65.65%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,833,800.00	2,516,800.00	(1,317,000.00)	65.65%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	357,100,500.00	346,494,666.00	(10,605,834.00)	97.03%
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,000,000.00	30,274,900.00	(2,725,100.00)	91.74%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,699,800.00	1,699,800.00	-	100.00%
210604	Урсгал засвар	322,400,700.00	314,519,966.00	(7,880,734.00)	97.56%

2107	Томилолт, зочны зардал	5,177,100.00	4,046,739.18	(1,130,360.82)	78.17%
210702	Дотоод албан томилолт	5,177,100.00	4,046,739.18	(1,130,360.82)	78.17%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	305,516,700.00	210,458,445.49	(95,058,254.51)	68.89%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,231,300.00	206,433,205.49	(93,798,094.51)	68.76%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	900,000.00	-	(900,000.00)	0.00%
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	250,000.00	-	100.00%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	659,900.00	303,194.00	(356,706.00)	45.95%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	22,000.00	(3,000.00)	88.00%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	607,500.00	607,500.00	-	100.00%
210807	Газрын төлбөр	2,843,000.00	2,842,546.00	(454.00)	99.98%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	548,518,300.00	533,341,158.00	(15,177,142.00)	97.23%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	541,139,700.00	526,791,158.00	(14,348,542.00)	97.35%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,378,600.00	6,550,000.00	(828,600.00)	88.77%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,556,000.00	37,918,328.00	(1,637,672.00)	95.86%
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,556,000.00	37,918,328.00	(1,637,672.00)	95.86%
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,000,000.00	17,000,000.00	(1,000,000.00)	94.44%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,556,000.00	20,918,328.00	(637,672.00)	97.04%
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,521,651,900.00	3,310,785,223.87	(210,866,676.13)	94.01%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,504,651,900.00	3,285,729,491.87	(218,922,408.00)	93.75%
320001	Орон нутгийн төсвөөс	3,504,651,900.00	3,285,729,491.87	(218,922,408.00)	93.75%
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,000,000.00	25,055,732.00	8,055,732.00	147.39%
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,000,000.00	25,055,732.00	8,055,732.00	147.39%
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,000.00	1,000.0	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	84.00	84.00	-	100.00%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	84.00	84.00	-	100.00%
620001	Удирдах ажилтан	21.00	21.00	-	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	55.00	55.00	-	100.00%
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00%
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,427,211.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,427,211.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,583,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,617,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,617,000.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	28,966,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,966,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,844,011.00
2133	Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,844,011.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,844,011.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	51,427,211.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	51,427,211.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	7,630,001.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	43,077,210.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	720,000.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 708,270.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Тайлант оны элэгдлийн зардлыг 232,549.8 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол дансанд тусгаж залруулав.

2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн цалингийн зардалд 51,460.0 мянган төгрөгийн бараа, материалын зардал тайлагнасан нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” болон “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн бичиг хэрэг зардалд тусгаж залруулав.

3. Санхүүгийн тайланд арилжааны банкны харилцах дансны үлдэгдэл 1.0 мянган төгрөгийг тайлагнаагүй нь УСНББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга” болон “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тусгаж залруулав.

4. Санхүүгийн тайланд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 420,660.1 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” болон “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлого дансанд тусгаж залруулав.

5. Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд зардлаар тайлагнасан нь УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө” болон “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд залруулав.

Мөн аудитаар нийт 3,869,467.5 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 2,410.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 3,858,799.4 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 8,257.7 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах 3 зөрчилд 2,410.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Жижиг мөнгөн сангаар илүү тооцож гаргасан 800.0 мянган төгрөгийн шагналын дагалдах мөнгийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, зарцуулах эрхгүй 720.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана”, 3.1-д “Төсөвт байгууллага нь Төрийн сангийн бүртгэлийн данснаас байгууллагын төлбөрийн картын дансаар дамжуулан бэлэн мөнгийг байгууллагын касс хүлээн авч зориулалтын дагуу зарцуулах үүргийг хүлээнэ”, 3.7.6-д “Бэлэн мөнгөний төлбөрийн картын дансаар энэ журмаар зөвшөөрснөөс бусад орлого, зарлагын гүйлгээ хийх” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Тайлант онд “Ривал констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн “Шат, хонгилын засвар”-ын ажлын төсөвт тусгагдсан 400.0 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардлыг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

3. Тус газар нь “НИК” ХХК-ийн Дархан нефть хангамжийн салбартай байгуулсан ДУАДАСЗДТГ/202212007 тоот гэрээний дагуу худалдан авсан шатахууны талонд ногдох хөнгөлөлт 490.4 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтгүй зарцуулсан нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан зарчим, 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, 14 дүгээр зүйлийн 14.4.2-д *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Аудитаар нийт 3,858,799.4 мянган төгрөгийн 4 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд “Ривал констракшн” ХХК-ийн гүйцэтгэсэн “Хүлээлгийн өрөө, коридорын засвар”-ын ажлын зураг, төсөвт тусгагдсан 4,390.4 мянган төгрөгийн “Хатжуулсан шилэн хана” угсрах, 420.0 мянган төгрөгийн “Дархан сумын ЗДТГ” хаяг хийх, 8,165.8 мянган төгрөгийн дроз дэвсэх зэрэг ажлууд хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д *“Гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах”*, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д *“Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна”*, “Ривал констракшн” ХХК-тай байгуулсан 4 дугаартай ажил гүйцэтгэх гэрээний 7.3-д *“Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл ГТН-д гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдээдлийг гүйцэтгэгчид хүргүүлнэ”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Нягтлан бодогч нь жижиг мөнгөн сангийн 15,324.0 мянган төгрөгийн гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, мөн анхан шатны баримтын бүрдэл хангаж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”*, 14 дүгээр зүйлийн 14.4.1-д *“аж ахуйн бүх ажил, гүйлгээ”*, 20.1.4-т *“хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”*, Сангийн сайдын 2017 оны

347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Төсвийн шууд захирагч нь 3,830,499.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөд бүртгэлээр хяналт тавиагүй, хөрөнгийн тооллогыг чанаргүй гүйцэтгэсэн, бараа, материалыг тоолоогүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4-д “комиссын хурлаар үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, 73 дугаар зүйлийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхийн зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “толилуулга” батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Дархан сумын ЗДТГ-т эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн 259,732 кв 7 газрыг данс бүртгэлд тусгаагүй нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасан үүрэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу үнэлж бүртгэнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд 3 албан хаагчийн 1,543.5 мянган төгрөгийг тайлагнаагүй нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тайлагнаагүй 3 албан хаагчийг нөхөн тайлагнаж, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд нийгмийн даатгалын тайланд тайлагнаж байх.

2. Татварын зардалтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Албан хаагчдад олгосон шагналын дагалдах мөнгөн шагналаас 1,001.0 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шагналын дагалдах мөнгөн шагналаас хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж холбогдох төсөвт төвлөрүүлж ажиллах, цаашид дээрх алдааг давтан гаргахгүй байх.

3. Бараа, материалын зардалтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авсан 5,713.2 мянган төгрөгийн шатахуун, аж ахуйн материалыг орлогод аваагүй, шууд зардлаар бүртгэсэн нь УССНБОУС 12 “Бараа материал”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн бараа, материалыг тооцооны дансаар дамжуулан, бараа материалд тусгаж, үлдэгдлийг үнэн зөв тайлагнаж байх.

4. Өглөг, авлагатай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагч аж ахуй нэгж байгууллага, иргэдтэй үүссэн өр төлбөр, авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5, 20.2.6 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг гаргахын өмнө харилцагч байгууллага, иргэдтэй үүссэн өр төлбөр, авлагыг тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

5. Автомашинтай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг солиулаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасантай нийцэхгүй байна.

5.2. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн улсын дугаарын дэвсгэр өнгийг бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий дэвсгэрээр сольж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дархан сумын ЗДТГ	5	708.3	3	424.3	2	284.0	5	708.3	-	-	-	-
Дүн	5	708.3	3	424.3	2	284.0	5	708.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дархан сумын ЗДТГ	12	3,869.5	3	2.4	4	3,5858.8	5	8.3	-	-	-	-
Дүн	12	3,869.5	3	2.4	4	3,5858.8	5	8.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
					Албан шаардлага		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дархан сумын ЗДТГ	1	3,719.1	-	-	1	3,719.1	-	-
Дүн	1	3,719.1	-	-	1	3,719.1	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-